



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 356

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дах хэсэг 1.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 2,075,629,750.00 (хоёр тэрбум далан таван сая зургаан зуун хорин есөн мянга долоон зуун тавин) төгрөгийн үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг Говь-Алтай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлд барьж, ашиглалтад оруулсан, нийт 4,115,500,000.00 (дөрвөн тэрбум нэг зуун арван таван сая таван зуун мянган) төгрөгийн үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан хөрөнгийг Нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа Ж.Болд, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга М.Баяраа, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Дашпунцаг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

3.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


Д.НАРАНГЭРЭЛ

132001292

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 07 дүгээр сарын 24 ны өдрийн
13 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Төсөл, арга хэмжээний нэр, байршил		Үндсэн хөрөнгийн нэр, төрөл, ангилал	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Ашиглагч байгууллага
Д/д					огноо	дугаар	
1. Барилга байгууламж							
1	Конторын барилга (Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум)	Үндсэн хийц	Тэнхлэгээрээ 30.0м x18.0м хэмжээтэй, зoorьтой, 3 давхар, цутгамал төмөр бетон каркасан барилга	1,771,731,156.00	2020.12.24	КД-90/2020	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар
1.1	Дээвэр		448.24 м2	106,627,740.00			
1.2	Гадна дулаан, цэвэр, бохир ус	Дулааны шугам	Дулааны шугам- 110 м	114,923,070.00			
		Гадна бохир	Гадна бохир -34.0м				
1.3	Гадна цахилгааны шугам	Цэвэр ус	Цэвэр ус-110 м				
			Гадна цахилгааны шугам-140 м	36,927,635.00			
	Дүн			2,030,209,601.00			
1.2.Бусад үндсэн хөрөнгө							
2.1	Гадна зам талбай		Авто зам 620 м2	45,420,149.00	2020.12.24	КД-90/2020	
			Явган зам 240м2				
	Дүн		Жагсаалын талбай 450 м	45,420,149.00			
	Нийт дүн			2,075,629,750.00			



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12, 7 дүгээр сарын 28-ны өдрийн
18 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл, ангилал	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Ашиглагч байгууллага
					огноо	дугаар	
1.1.Барилга байгууламж							
1.1	Конторын барилга, (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо)	Үндсэн хийц	22м х33м хэмжээтэй зоорьтой, 15Мм*30м хэмжээтэй 6 давхар, цутгамал төмөр бетон каркасан барилга	3,886,224,010.00	2020.07.01	374/2020	Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар
			Дулааны шугам- 60м	97,653,732.00			
			Гадна бохир -60м				
1.2	Гадна дулаан, цэвэр, бохир ус	Дулааны шугам	Цэвэр ус-60м	32,249,707.00			
		Гадна бохир					
1.3	Гадна цахилгааны шугам	Цэвэр ус	гадна цахилгааны шугам- 50м	4,016,127,449.00			
	Дүн						
1.2.Бусад үндсэн хөрөнгө							
1.2	Гадна зам талбай		800м2	99,372,551.00	2020.07.01	374/2020	
	Дүн			99,372,551.00			
	Нийт дүн			4,115,500,000.00			